



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 8/04

Жавхлант

Т.Эрдэнэцэцэгт ажил хавсран
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/114 тоот тушаалын /хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай/ 1 дүгээр зүйлийн “в”, “Хөдөлмөрийн тухай” хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүүгийн албаны дарга Төмөрхуягийн Эрдэнэцэцэгт байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг хариуцсан ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 20%-иар тооцож сар бүр олгохыг Нягтлан бодогч (С.Наранцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Б/39 тоот тушаалыг хүчингүйд тооцугай.

4. Холбогдох хууль, журмын дагуу хийсэн ажлын тайланг сар бүрийн сүүлийн өдөр Төсвийн шууд захирагчид тайлагнаж, эрхэлсэн ажилдаа идэвх санаачилгатай гүйцэтгэхийг Санхүүгийн албаны дарга (Т.Эрдэнэцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Р.ОЮУНЧИМЭГ